

МОНГОЛЧУУДЫН ТУУЛЬ ХАЙЛАХ УЛАМЖЛАЛТ ЁС ЗАНШИЛЫН ТУХАЙ

С.Байгалсайхан доктор (Sc.D), профессор,
Б.Сайнгэрэл МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулийн
Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн докторант

Монголчууд бидний өвөг дээдсийн хэдэн зуун жил, хэдэн үеэр бүтээн туурвиж хадгалан үлдээж ирсэн оюуны их өв эрдэнэ бол монгол баатарлаг туульс билээ. Монгол тууль бол монгол ардын аман билгийн нэн эртний төрөл хэлбэрийн нэг бөгөөд хэдэн зуугаас хэдэн түмэн мөр шүлгээс бүрдэл болдог том туурвил билээ.

Туульсийн бүтээлүүд нь эртний цалиг шүтлэг, бөө мөргөл, бурханы шашин, домог зүйн болон уран сайхны сэтгэлгээний олон үе давхрагыг хадгалсан бөгөөд дотроо үлгэр, домог, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, цацал мялаалга, бэлгэ дэмбрэлийн үг, дом шившлэг зэрэг аман зохиолын олон төрөл зүйлийг багтаан агуулж байдаг онцлогтой.

Монгол туулийн хэл гайхамшигтай уран яруу бөгөөд монгол шүлгийн шилдэг уламжлалыг хадгалсан, эртний хэллэг, монголын олон ястан овогтны аман аялгууны онцлогийг агуулсан байдаг.

Монголчууд эртнээс нааш туулийг хүндлэн дээдлэж, дайн тулаан, ан авд мордох, уул ус тахих,, амьдрал ахуйгаа сайжруулах зэрэг иргэний болоод төрийн ёслолын үед тууль хайлуулж ирсэн уламжлалтай. Тууль төрийн ёсонд төдийгүй гэрийн ёсонд хүндтэй байр эзэлдэг.

Монголчуудын тууль хайлах уламжлал ёс заншилийг нарийвчлан судлахад байгаль орчин, цаг уур, угсаатны аж байдал, билэгдэлийг харуулсан өвөрмөц онцлогууд байна. Тухайлбал: Хангайн нутгийн өндөр өндөр Алтайн ноён оргилууд, гол мөрөн, ой мод ихтэй бүс нутгийн баяд дөрвөд алдарт туулчид тууль хайлахын өмнө хэлдэг магтаал шүлгийг “Алтай хайлах” гэдэг нэртэй тусгай үйл явдал, тодорхой баатар бүхий тууль товшуур хөгжимтэй хэлдэг байна. Урианхайн алдарт туульчид “Алтайн магтаал”-ыг товшуур хөгжмийн аялгуунд магтан хэлцгээдэг байна. Урианхай туульчид товшуур хөгжмийг өөрсдөө урлаж хурдан удамтай азарганы сүүлээр товшуурын хялгасыг хийдэг бөгөөд товшуур хөгжимөөр тууль хайлахад ямар нэгэн далдын ид шидийг бүрдүүлэхэд багагүй үүрэгтэй эрхэм зүйл гэдэг байна. Иймээс тууль хэлүүлэх айл туульчийнд очиж тууль хайлж өгөхийг сонсгоод туульчийн зөвшөөрснөөр товшуурыг нь тусгай даавуунд ороож гэртээ урьдчилан залж хүндтэй байранд тавьдаг байжээ. Тууль хайлж дууссаны сүүлд гурваас долоо хоног тэр товшуурт хүн гар хүрэх ёсгүй, гэрийн эзэн сүүлд туульчийнд хүргэж өгдөг нарийн дэглэмтэй байжээ. Туульч урьсан айл гэртээ даалимба, бүтэн цай, тамхи зэрэг толгой бараа оруулж, товшуурын чихнээс буюу толгойноос нь цагаан бөс уядаг байжээ.

Говь нутгийн халуун дулаан уур амьсгалтай, уул, ус мөрөн багатай, өвс ногоо тачир ургадаг онцлогтой бүс нутгийн халхын алдарт туульчид тууль хайлж эхлэхийн өмнө хайлах туулийн гол баатарын амьдран суудаг нутаг, ус, мал сүрэг, ан амьтан, жигүүртэн шувууд, өргөө гэрийг морин хуур хөгжмийн аялгуунд, аман аялгуугаар аялгуулан магтахаас гадна үлгэрлэн ярьдаг байна.

Говийн халхчууд тууль хайлуулахаар туульчийг өргөө гэртээ залахдаа жороо морь хөтлөн очиж туульчаа авдаг байна. Туульчийг ирэхэд сүүтэй цай чанаж, өрөмтэй цагаан идээ засаж, уул усны эзэд лусууд нэгнээсээ өрсөж тууль сонсох гэдэг, тэгээд баярлан баясдаг хэмээн билэгдэн зул барин, арц ганга угуулдаг байна. Халхын алдарт туульч Лодон гуай тууль хайлахдаа зассан идээний өрмөн дээрээс халбагаар авч данхтай цайны цорго болон домботой цайныхаа амсар дээр өрөм тавьж тууль хайлж дуусахад өрөм нь туулийн авшиг шингээн халуун цайнд хайлан орж идээ цайгаа мялаадаг зан үйл үйлддэг байжээ. Ингэснээр уулс улсны эзэн лусууд баясаж байгаль дэлхий хур бороо хайрлаж, цаг ногоо дэлгэрч, мал сүргийн зоо тэнийж, айл хотлоороо элбэг баян байхыг билэгддэг. Тууль хайлж дуусмагт бүх хүн гурвантаа хурайлж өлзий хутагийг оршоодог бөгөөд тууль хайлуулсан айл туульчийг хүндэтгэн эдийн дээд хадаг, идээний дээд цай өгдөг уламжлалт ёс заншилтай.

Ном зүй

1. Цолоо. Ж Монгол ардын баатарлаг тууль УБ. 1982. Ху 4,10.

2. Нарантуяа. Р “Түүхэн туурвил зүйн судалгааны онол түүхийн асуудал” илтгэл Төв Азийн тууль УБ. 1997. Ху 112., Төв Азийн тууль анхдугаар симпозиумын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.
3. Сайнгэрэл. Б Өмнөговийн туульчид УБ. 2020. Ху 24.

Хээрийн судлагааны тэмдэглэл

4. ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн сан хөмрөг Х-5, ДТ-49а, ХН-15.
5. Халх туульч Санжийн Лодон агсны охин Л.Хорлоотой уулзсан хээрийн судлагааны тэмдэглэл Өмнөговь аймаг, Даланзадгад сум. 2022.03 сар.
6. Халх туульч Санжийн Лодон агсны охин Л.Хорлоотой уулзсан хээрийн судлагааны тэмдэглэл Өмнөговь аймаг, Даланзадгад сум. 2022.05 сар.
7. Халх туульч Цэвэгмидийн Дэжид агсны охин Бямбасүрэнтэй уулзсан хээрийн судалгааны тэмдэглэл Улаанбаатар хот. 2023.03 сар.